

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2026/13/НА-СТА-ОНА

Цахим www.audit.mn Дорноговь аймаг 2026 он	хуудас:	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.03.13 № 1-6/316

танай _____-ны № _____-т

Г ХАМАРЫН ХИЙДИЙН ТУСГАЙ Г
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ЗАХИРГАА ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ш.БАЙГАЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Дорноговь аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас тус байгууллагын 2024 он, 2025 оны 1 дүгээр улирлын санхүү, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтаар илэрсэн 5,098.5 мянган төгрөгийн асуудал нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй гэж үзэн хууль хяналтын байгууллагад шилжүүлснийг аймгийн прокурорын байгууллагаас 2025 оны 11 сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн байна.

Бид тус байгууллагаас шүүхэд гаргасан нэхэмжлэлийн үр дагавартай холбоотой эргэлзээг тодорхойлсон санхүүгийн тайлангийн Тайлбарт анхаарал хандуулж байна. Энэ асуудалтай холбоотойгоор бидний санал дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

442505291

Бусад асуудлын хэсэг

2025 онд эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,987,420.43	37,613,853.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	244,780.29	214,288.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	244,780.29	214,288.30
3121	Төгрөг	244,780.29	214,288.30
31211	Төрийн сангийн харилцах	244,780.29	214,288.30
33	АВЛАГА	301,971.14	252,362.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	49,609.14	-
335	Бусад авлага	252,362.00	252,362.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	252,362.00	252,362.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,440,669.00	37,147,202.75
351	Түүхий эд материал	13,200,000.00	1,406,900.00
35110	Тусгай зориулалттай материал	13,200,000.00	1,406,900.00
354	Хангамжийн материал	28,240,669.00	35,740,302.75
35410	Бичиг хэргийн материал	1,801,400.00	1,272,300.00
35420	Аж ахуйн материал	5,062,812.00	25,626,608.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,989,900.00	2,251,900.00
35440	Түлш, шатах тослох материал	16,001,557.00	6,204,494.75
35450	Барилгын засварын материал	385,000.00	385,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,410,426,864.07	1,254,038,478.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,410,426,864.07	1,254,038,478.94
392	Биет хөрөнгө	1,409,546,864.07	1,234,360,478.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,862,657.60	352,862,657.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41,664,727.22)	(70,293,400.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	255,129,680.00	255,129,680.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,021,942.56)	(101,208,243.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,741,530.00	131,757,530.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,879,121.19)	(43,571,834.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,297,808.00	23,297,808.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,617,493.45)	(7,914,433.49)
39212	Хуримтлагдсан элэгдэл	(34,459,999.19)	(38,839,999.07)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	48,695,000.00	48,695,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,012,226,920.00	1,012,226,920.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(211,763,447.92)	(327,781,205.58)
393	Биет бус хөрөнгө	880,000.00	19,678,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(1,100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	19,128,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,452,414,284.50	1,291,652,331.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	79,609.14	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	79,609.14	-
413	Өглөг	79,609.14	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	79,609.14	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,452,334,675.36	1,291,652,331.99
51	Засгийн газрын хувь оролцоо	1,452,334,675.36	1,291,652,331.99
512	Хуримтлагдсан үр дүн	1,452,334,675.36	1,291,652,331.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,452,334,675.36	1,452,334,675.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(160,682,343.37)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,452,414,284.50	1,291,652,331.99

Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2025
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,751,942,411.08	767,942,304.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,751,942,411.08	723,271,804.64
120	Нийтлэг татварын бус орлого	1,730,208,711.08	723,271,804.64
120002	Хүүгийн орлого	208,704.64	368,798.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	670,000,000.00	674,627,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	670,000,000.00	674,627,500.00
120009	Бусад орлого	845,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,059,155,006.44	19,128,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		29,147,505.75
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	21,733,700.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	21,733,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	44,670,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	44,670,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	44,670,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	820,712,819.08	928,624,648.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,712,819.08	928,624,648.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,112,819.08	925,368,621.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,606,369.45	482,269,774.64
210101	Үндсэн цалин	361,096,369.45	413,940,629.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,510,000.00	68,329,145.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,748,517.58	54,264,248.96
210201	Тэтгэврийн даатгал	33,528,235.96	37,254,187.56
210202	Тэтгэмжийн даатгал	4,202,347.94	4,830,049.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,384,014.93	2,687,982.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,713,417.90	1,898,403.17
210205	Эрүүл мэндийн даатгал	6,920,500.85	7,593,626.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,628,548.95	20,851,860.39
210301	Гэрэл, цахилгаан	12,106,222.45	16,766,089.39
210302	Түлш, халаалт	3,522,326.50	3,761,051.00
210303	Цэвэр, бохир ус	-	324,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,873,926.35	100,306,592.00
210401	Бичиг хэрэг	2,013,000.00	54,707,512.00
210402	Тээвэр, шатахуун	36,809,089.00	35,400,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,176,577.35	6,712,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,486,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	53,875,260.00	-
2105	Нормативт зардал	11,850,000.00	264,000.00
210502	Хоол, хүнс	11,850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	264,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,990,930.00	39,423,350.00
210604	Урсгал засвар	7,990,930.00	39,423,350.00
2107	Томиллолт, зочны зардал	11,790,000.00	12,640,000.00
210702	Дотоод албан томиллолт	10,660,000.00	12,640,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,130,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,385,540.67	3,789,809.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,615,030.00	1,376,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,471,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,750.00	515,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,734.00	126,674.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	99,000.00

Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2025
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000,000.00	-
210807	Газрын төлбөр	38,256.00	38,256.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	157,770.67	162,979.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	186,238,986.08	211,558,985.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,190,400.00	450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	668,700.00	1,576,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	182,379,886.08	209,532,385.13
212	ТАТААС	-	2,146,027.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	2,146,027.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	2,146,027.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,600,000.00	1,110,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	1,110,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,110,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	931,229,592.00	(160,682,343.37)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	931,229,592.00	(160,682,343.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	692,787,404.64	719,666,798.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	692,787,404.64	674,996,298.89
120	Нийтлэг татварын бус орлого	671,053,704.64	674,996,298.89
120002	Хүүгийн орлого	208,704.64	368,798.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	670,000,000.00	674,627,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	670,000,000.00	674,627,500.00
120009	Бусад орлого	845,000.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	21,733,700.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	21,733,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	44,670,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	44,670,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	44,670,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	665,395,308.30	685,681,290.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665,395,308.30	685,681,290.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	663,795,308.30	682,425,263.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,968,945.54	482,269,922.51
210101	Үндсэн цалин	426,968,945.54	482,269,922.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,947,018.79	54,294,101.09
210201	Тэтгэврийн даатгал	57,947,018.79	54,294,101.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,521,407.95	21,017,360.39
210301	Гэрэл, цахилгаан	12,106,222.45	16,766,089.39
210302	Түлш, халаалт	4,415,185.50	3,926,551.00
210303	Цэвэр, бохир ус	-	324,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,491,727.35	37,777,860.00
210401	Бичиг хэрэг	3,301,700.00	1,551,000.00
210402	Тээвэр, шатахуун	52,300,000.00	24,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,176,577.35	6,712,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	191,400.00	5,514,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	522,050.00	-
2105	Нормативт зардал	27,919,548.00	1,343,760.00
210502	Хоол, хүнс	11,850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,069,548.00	1,343,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,451,580.00	36,289,350.00

Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2025
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	462,000.00	-
210604	Урсгал засвар	11,989,580.00	36,289,350.00
2107	Томилолт, зочны зардал	11,790,000.00	12,640,000.00
210702	Дотоод албан томилолт	10,660,000.00	12,640,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,130,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,474,690.67	33,649,809.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,116,180.00	31,236,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	588,000.00	1,471,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,750.00	515,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,734.00	126,674.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000,000.00	-
210807	Газрын төлбөр	38,256.00	38,256.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	157,770.67	162,979.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,230,390.00	3,143,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,561,690.00	450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	668,700.00	2,693,100.00
212	ТАТААС	-	2,146,027.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	2,146,027.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	2,146,027.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,600,000.00	1,110,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	1,110,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,110,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,392,096.34	33,985,508.01
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,727,230.00	34,016,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,727,230.00	34,016,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,727,230.00	34,016,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	34,016,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,727,230.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(30,727,230.00)	(34,016,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,335,133.66)	(30,491.99)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		244,780.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	244,780.29	214,288.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	1,452,334,675.36	1,452,334,675.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,452,334,675.36	1,452,334,675.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн есөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(160,682,343.37)	(160,682,343.37)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,291,652,331.99	1,291,652,331.99

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангахаар заасан боловч тайлант онд батлуулаагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,110.2 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулж алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Эдийн засгийн ангилал буруу тайлагнасан.

Аудитын явцад 3 зөрчил илрүүлж 1 албан шаардлага, 1 зөвлөмж, хариуцлага тооцуулах албан шаардлагыг дээд шатны төсөв захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1 Төлбөрийн акт

2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. 2022 онд үүссэн хувь хүнээс авах 252.4 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлээгүй.
2. Өмнө онд өгсөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж ажиллах албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэр төрлийн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн стандартын дагуу хэрэв тухайн хөрөнгийг цаашид үргэлжлүүлэн ашиглах бол дахин үнэлгээ хийлгэж, цаашид ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох, дахин ашиглахгүй бол данснаас хасах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
	Эдийн засгийн ангилал буруу тайлагнасан.	1	34,110.2			1	34,110.2	1	34,110.2		
	Дүн	1	34,110.2			1	34,110.2	1	34,110.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийг шийдвэрлээгүй	1	-							1	-		
2	Насжилт өндөртэй авлагыг шийдвэрлээгүй.	1	252.4			1	252.4						
	Өмнө оны албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй	1										1	1
	Дүн	3	-			1	252.4	1		1		1	1